## САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 08 Номгон

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| Төсвийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөж, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангана. | | | | | | | | |
| 1 | **1.“Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1.1 | Төсөвт байгууллагуудаас төсвийн төслийг хүлээн авч нэгтгэн боловсруулж 2026 оны төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлж, хянуулах | Байгууллагын төсвөөс | Зардлын төрөл зүйл тус бүрээр судалгааг хүлээн авч нэгтгэн батлуулсан байгууллагын тоо | 168 | 168 | 0 | Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлого зарлагын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд судалгаа, бүртгэл таамаглал, тооцоололд үндэслэн байгууллага тус бүрээр гаргуулан авахаар аймгийн Засаг даргын 1а/421, 1а/422 дугаар албан бичгүүдийг сум, байгууллагуудад хүргүүлээд байна. Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу 2025 оны 7 дугаар сарын 25-ны дотор | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлж хянуулахаар боловсруулж эхлээд байна. | |
| 1.2 | Төсвийн тодотгол хийх нөхцөл үүссэн тохиолдолд тодотголын төслийг боловсруулж, батлуулах | Байгууллагын төсвөөс | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсноор | 1 | 1 | 1 | Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дах хэсэгт заасны дагуу Төсвийн тодотгол хийх нөхцөл үүсээгүй байна | 0% |
| 1.3 | Улсын их хурлаар батлагдсан төсөвт хуваарилалт хийж, аймгийн 2026 оны төсвийг сум байгууллага тус бүрээр боловсруулан хуулийн хугацаанд АИТХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлэн батлуулах | Байгууллагын төсвөөс | Аймгийн 2026 оны төсвийн тогтоолыг батлуулсан байгууллагын тоо | 168 | 0 | 168 | Төсвийн тухай хуульд 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу 2025 оны 12 дугаар сарын 5-ны дотор батлуулах тул төлөвлөгөөт хугацаа болоогүй байна | 0% |
| 1.4 | Аймгийн төвлөрсөн төсөв болон 20 сумын батлагдсан төсвийн хуваарийг төсвийн төлөвлөтийн fiscal программд байгууллага, сар тус бүрээр, орлого зарлагын хуваарийг эдийн засгийн ангиллаар шивж төсвийн зарцуулах эрхийг нээлгэх | Байгууллагын төсөв | Программд бүрэн шивж гүйцэтгэлд хяналт тавьсан байгууллагын тоо | 207 | 207 | 207 | Аймгийн 2025 оны төсөв баталсан тогтоол, Сумдын 2025 оны төсөв баталсан тогтоолуудыг нэгтгэн төсвийн төлөвлөлтийн Фискал программд 2025 оны 1 дүгээр сард байгууллага, сан тус бүрээр орлого, зарлагын хуваарийг эдийн засгийн ангилал тус бүрээр шивж тухай бүр гүйцэтгэлд хяналт тавьж шаардлагатай тохиолдолд тухай бүр төсөвт зохицуулалт хийж төсвийн зарцуулах эрхийг нээснээр | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зарлага, санхүүжилт хэвийн явагдаж байна. | |
| 1.5 | Орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил тасралтгүй ажилласан төрийн захиргааны албан хаагчдын тэтгэмжийг хянаж санхүүжүүлэх | Байгууллагын төсөв | Тэтгэмжийг олгосон хувь | 100% | 100% | 100% | Одоогийн байдлаар Орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил тасралтгүй ажилласан төрийн захиргааны албан хаагчдын урамшууллын материалыг хянаж 9 албан хаагчийн 81.2 сая төгрөгийн урамшууллыг шилжүүлсэн байна | 100% |
| 1.6 | Сумдын санхүүгийн алба, төсөвт байгууллагуудад ажлын байрны сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах | Байгууллагын төсөв | Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн сумын тоо | 19 | 10 | 9 | Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдад ажлын байрны сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах удирдамжийг батлуулан хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна | 50% |
| **2.“Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж далд эдийн засгийг бууруулан татварын орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 2.1 | Иргэн, хуулийн этгээдийн татварын албаны мэдээллийн баазад бүртгэлтэй болон бүртгэлгүй үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдох үнэлгээг хянаж, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх | Байгууллагын төсөв | Орлогын гүйцэтгэл /сая.төг / | 2,229.4 | 5,141.1 | | 5 дугаар сарын байдлаар АТБӨЯХАТатвар 492,273.4 мянган төгрөг буюу 115.8 хувь, газрын төлбөр 266331.3 мянган төгрөг буюу 152.3 хувь, ҮХЭХАТатвар 601,139.2 мянган төгрөг буюу 320 хувь, галт зэвсгийн албан татвар 21,407 мянган төгрөг буюу 892 хувиар | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | давж биелсэн үзүүлэлттэй байна. Нийт дүнгээрээ эхний 4 сарын байдлаар хөрөнгийн орлогын татвараар 1,114,819.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. Мөн хөрөнгийн татвар төлөгчдийн мэдээллийн зөрүүг арилгах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор "Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 155 дахь заалтын хэрэгжилтийг хангах, Аймгийн Засаг даргын А/279 дугаар "Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, хяналтын ажлыг эрчимжүүлэх тухай" захирамжийг боловсруулан батлуулж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Татварын газрын дарга, Улсын бүртгэлийн хэлтсийн даргын хамтарсан удирдамжаар ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус удирдамжийн хүрээнд 05 дугаар сарын 25-с 27-ны өдрүүдэд Шинэжинст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сэкер Ресорсус Монголиа ХХК болон Эрдэнэ Монгол ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, удирдамжийн дагуу хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн. | |
| 2.2 | Аймаг сумдын төсвийн орлогын гүйцэтгэлийг сар бүр Татварын газартай хамтран хянаж, Сангийн яамны мэдээлэлтэй тулган мэдээний үнэн зөв байдлыг хангаж ажиллах | Байгууллагын төсөв | Орлогын гүйцэтгэл зөрүүгүй байх | орлогыг зөрүүгүй хаасан | орлогы г зөрүүгү й хаасан | орлогыг зөрүүгү й хаасан | Сар бүрийн төсвийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын газартай хамтран гарган, Сангийн яамны мэдээлэлтэй тулган мэдээний үнэн зөв байдлыг хангаж ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сум бүрээр нягтлан дүн шинжилгээ хийж, гүйцэтгэл бага, тасрах эрсдэлтэй татварын нэр төрлүүдэд онцгой анхаарч, хяналт тавин, шалтгаан нөхцлийг тодруулж, холбогдох сум байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллаж байна. | 100% |
| 2.3 | Улсын, орон нутгийн татварын болон татварын бус орлогыг цаг хугацаанд нь, нэр төрөл тус бүрээр төвлөрүүлэх | Байгууллагын төсөв | Орлогын гүйцэтгэл | 35396,7 | 46080, 4 | 46080,4 | 2025 оны 5 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээгээр улсын төсвийн орлогын гүйцэтгэл 114,1 хувь буюу 2,595.3 сая төгрөг, орон | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нутгийн төсөв 15,296 сая төгрөг буюу 115,8 хувиар биелсэн байна. Улсын болон орон нутгийн татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 18,940.3 сая төгрөг буюу 114,5 хувь биелсэн үзүүлэлттэй байна. | |
| 2.4 | Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээнүүдийн үүргийн биелэлтийг ханган, хуваарийн дагуу 2025 онд төлөх төлбөрүүдийг улсын төсөвт төлж барагдуулах арга хэмжээг авах | Байгууллагын төсвөөс | Төлсөн дүн /сая.төг/ | 307,6 | 302,2 | 302,2 | Дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийн зээл төлөх хуваарь болоогүй байна. | 0% |
| **3.“Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 3.1 | Аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-баланс цахим хэлбэрээр хүлээн авч, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулах арга зүйгээр хангаж ажиллах | Байгууллагын төсвөөс | Санхүүгийн тайланг баталгаажуулах хувь | 82% | 83% | | 2024 онд тайлан ирүүлэх 2127 аж ахуйн нэгж байгууллагаас тайлан ирүүлээгүй 383 аж ахуйн нэгж, 1744 аж ахуйн нэгж байгууллага тайлан ирүүлж, тайлангийн ирц 83 хувь<br>Үр дүн: Зорилтод түвшинд хүрсэн. | 100% |
| 3.2 | Шинээр үүсэн байгуулагдсан АА нэгжүүдэд И-Баланс цахим системд нэвтрэх, | Байгууллагын төсвөөс | Шинээр системд холбогдсон ААН-ын тоо | 1408 | 250 | 250 | 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл 86 аж ахуйн нэгж | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | системд холбох, цахим бүртгэлийн талаар заавар зөвлөгөө өгөх | | | | | | байгууллага шинээр үүсэн байгуулагдаж эдгээр аж ахуйн нэгж байгууллагуудыг нэвтрэлтийн нэгдсэн системд нэвтрэх, байгууллага холбох, нээлтийн тайлан гаргах, санхүүгийн тайлан гаргах,бүртгэлийн талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна. | |
| 3.3 | Төрийн аудитын газраас төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмж, акт албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн нэгдсэн дүн тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэх | Байгууллагын төсвөөс | Төрийн аудитын газраас ирүүлсэн зөвлөмж, акт албан шаардлагад төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах хувь | 100% | 100% | 100% | Төрийн аудитын газраас төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмж, акт албан шаардлагад хариу арга хэмжээ авах ажлын төлөвлөгөө гарган 2025 оны 05-р сарын 20-ний дотор төрийн аудитын газарт хүргүүлсэн. | 100% |
| 3.4 | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн FinPerform системийг нэвтрүүлэн тайлан хүлээн авч, нэгтгэх | Байгууллагын төсвөөс | Санхүүгийн тайлан хүлээн авалтын хувь | 100% | 100% | 100% | 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг байгууллагууд FinPerform системд шивсэн Сангийн яам программын хөгжүүлэлтийг хийж байгаа. | 50% |
| 3.5 | Санхүүгийн үйлчилгээг зөвшөөрөлгүй болон бүртгэлгүй эрхэлж буй | Байгууллагын төсвөөс | Ажлын байрны үзлэг шалгалт | 11 | 43 | 43 | Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид, Үнэт металл, үнэт чулууны, | 50% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэн, хуулийн этгээдэд Санхүүгийн зохицуулах хороотой хамтран болон дангаараа хяналт тавих | | хийсэн байгууллагын тоо | | | | эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд хороотой хамтран болон дангаараа хяналт шалгалт хийх журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд 2025.05.29-ны 7/745 албан бичгийг хүргүүлэн хамтарсан хяналтшалгалтыг хийхээр төлөвлөсөн байна. | |
| 3.6 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх журмын дагуу шийдвэрлэх | Байгууллагын төсвөөс | Зөрчлийг илрүүлж арга хэмжээ авсан тоо | 23 | 312 | 0 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн 11 нягтлан бодогчид хялбаршуулсан журмаар, Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуульд оролцож, сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй 310 нэр дэвшигчдын нэрсийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлж зөрчлийг шалган үзээд 299 нэр дэвшигчийн зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож 11 нэр дэвшигчид хялбаршуулсан журмаар /маягт 2/-оор шийтгэл оногдуулсан. | 100% |

**4.“Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэн, төрийн сангийн үйл ажиллагааг эрсдэл багатай явуулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Төрийн сангийн цахим дотоод хяналтын давтамжийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах | Байгууллагын төсвөөс | Төрийн сангийн 20 нэгж | 20 | 20 | | Төрийн сангийн үйл ажиллагаанд 2024 онд дотоод хяналт хийсэн ажлын тайланг Аймгийн Засаг даргын 2025 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн 1а/71 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Дотоод хяналтын шинэ журмын дагуу эрсдэлийн үнэлгээг хийхэд эрсдэл өндөр санхүүгийн алба байхгүй байгаа тул дунд, бага эрсдэл бүхий албадад улиралд 1 удаа цахим хяналт хийж, тойргын сумдад очиж ажиллах удирдамж батлуулан ажиллаж байна. | 70% |
| 4.2 | Төсөвт байгууллагуудад санхүүжилт, олгох, орлогын хаалтын журнал ваучер, нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийг нээх бичилтийг цахимаар хийхэд удирдлага арга зүйгээр хангах | Байгууллагын төсвөөс | Төсөвт байгууллагын тоо | 190 | 190 | | Эрхийн бүртгэлийн сан систем, Төрийн сангийн удирдлагын цахим системийн хөгжүүлэлтийн төслийн баг журнал ваучер, зарцуулалтын эрх, зарлагын гүйлгээг илүү хялбар хийх хөгжүүлэлтийг үе шаттайгаар хийж байна. Одоогоор санхүүжилт, залруулгын журналын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичилт цахимаар амжилттай хийгдэж байна. | |
| 4.3 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийсэн хяналт шалгалт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хамтарч ажиллах, Санхүүгийн албадад заавар зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах | Байгууллагын төсвөөс | Төрийн сангийн нэгжийн тоо | 21 | 21 | | Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас ирүүлсэн шилэн дансны цахим хуудасны 2024 оны 4 улирлын хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын материалтай танилцаж, сумдын санхүүгийн албанд дамжуулж ажилласан. Төрийн аудитын байгууллагаас 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд өгсөн зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 100% |
| **5. “Хууль, тогтоомж, олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журам, заавар, аргачлалыг таниулан сурталчлах, сургалт явуулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 5.1 | Санхүүгийн албаны дарга нарт “Хөгжлийн зорилт, төсвийн уялдааг хангасан үр дүнд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулна | Байгууллагын төсвөөс | Сургалт зохион байгуулж үр дүн суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлсэн сумын тоогоор | 0 | 20 | 20 | Хэлтсийн сургалтын төлөвлөгөөнд 2025 оны 9 дүгээр сард хийхээр тусгасан хэдийч сургалтын материалыг боловсруулж байна. | 0% |
| 5.2 | Төрийн сангийн үйл ажиллагааны шинэчлэн батлагдсан журмуудыг нэвтрүүлэх сургалтыг | Байгууллагын төсвөөс | Төрийн сангийн нэгжийн тоо | 21 | 21 | 21 | Аймгийн Засаг даргын 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн а/263 захирамжаар UPDATE арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цахимаар зохион байгуулах | | | | | | UPDATE WORK-2025 уралдааны удирдамжийн Хэлтсийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 36 дугаар удирдамжаар батлуулж, сумдын санхүүгийн албаны дунд 2025 оны 5 дугаар сарын 5-ний өдрөөс эхлэн зарласан. Уралдаанд оролцогч 20 сумын санхүүгийн албанаас уралдааны хийх ажлын төлөвлөөг хүлээн авсан. Тус арга хэмжээний хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 1,2-ны өдөр Санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нийт 36 албан хаагчдад UPDATE-ЧАДАВХЖУУЛАХ сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалтаар төрийн сангийн удирдлагын цахим системийн хөгжүүлэлт, эрхийн бүртгэлийн сангийн тохиргоо хийх, системд гардаг нийтлэг алдааг залруулах, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжилтийг сайжруулах, анхаарах асуудлаар сургалт мэдээллийг өгч, харилцан ярилцаж мэдлэг ахиулсан онцлогтой сургалт болсон. Мөн “Ажлын байрны стресс” сэдвээр мэдээлэл өгч, харилцаа хандлага сайжруулах, ажлын эрч хүч урам зориг өгөх, сэргээх хөгжөөнт тэмцээн уралдаан, арга хэмжээнүүдийг авч зохион байгуулсан нь тус сургалтын онцлог үр дүн байсан. Дээрх сургалт, уралдааны гол зорилго нь төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэл бууруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ажилдаа шинэчлэлт хийж, мэдлэг боловсролоо ахиулах, харилцаа хандлагыг сайжруулах замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх явдал юм. Мөн 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр цахим хэлбэрээр 33 санхүүгийн албан хаагчдад энэ сэдвээр сургалт орсон. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3 | “Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой гарч байгаа нийтлэг алдаа зөрчлийн залруулга” сургалтыг төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт зохион байгуулах | Байгууллагын төсвөөс | Нягтлан бодогчдын тоо | 66 | 66 | 68 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн 1/297, 1/401, 1/415, 1/428 албан бичгийн дагуу нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа зөрчлийг нэгтгэж сургалт зохион байгуулахад бэлтгэж байна. Хугацаа болоогүй. | 50% |
| 5.4 | Шинээр томилогдсон нягтлан бодогч, няравуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Байгууллагын төсөв | Нягтлан бодогчдын тоо | 15 | 20 | 20 | Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан зорилтыг хэрэгжүүлэх, байгууллагын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, эд хариуцагчдын мэдлэг чадвар, үүрэг хариуцлагыг өндөржүүлэн, зөрчил дутагдлыг бууруулах, хуулийн хэрэгжилтийг хангах, эд хариуцагч няравуудыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, Мэдээлэл арга зүйн төвөөс баталгаажсан мэргэжлийн түвшин, зэрэг бүхий чадамжийн гэрчилгээ олгох **НЯРАВ**-ын сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 9,10,11-ны өдрүүдэд зохион байгуулахаар 7/781 | 50% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан бичгийг сум, төсөвт байгууллагуудад хүргүүлсэн. | |
| 5.5 | Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Байгууллагын төсвөөс | Нягтлан бодогчдын тоо | 48 | 75 | 75 | Хугацаа болоогүй | 0% |
| 5.6 | Нягтлан бодогчдын дунд ур чадварын уралдаан зохион байгуулах | Байгууллагын төсвөөс | Нягтлан бодогчдын тоо | 0 | 66 | 0 | Хугацаа болоогүй | 0% |
| 5.7 | Тамгын газрын хэлтсүүдийн дунд олон төрөлт тэмцээн зохион байгуулах | Байгууллагын төсвөөс | Арга хэмжээ зохион байгуулснаар | 0 | 1 | 0 | Хоёрдугаар улиралд зохион байгуулна. | 0% |
| 5.8 | Хэлтсийн мэдлэг хуваалцах цагт мэргэжилтнүүдийг шинэ мэдээ мэдээллээр хангах | Байгууллагын төсвөөс | Шинэ мэдээлэл өгсөн тоогоор | 3 | 6 | 6 | Хэлтсийн мэргэжилтнүүдийн мэдлэг хуваалцах цагийг долоо хоног бүрийн 3 дахь өдөр товлож хуваарийг гарган төлөвлөгөөний дагуу мэдээлэл өгч байна. | 100% |
| 5.9 | Аймгийн ЗДТГазрын үйл ажиллагаанд олон улсын ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах | Байгууллагын төсвөөс | Өдөр тутмын үйл ажиллагаандаа Хэрэгжүүлж хэвших албан хаагчийн тоо | 8 | 8 | 8 | Аймгийн ЗДТГ-н даргын тушаалаар чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх чанарын багт хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн С.Бүжинлхам хэлтсийнхээ ISO- чанарын багийн гишүүнээр 04 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн томилогдон ажиллаж байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Стандарт, хэмжил зүйн ерөнхий газраас зохион байгуулсан MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага, MNS ISO 19011: 2020- “Менежментийн тогтолцоонд аудит явуулах арга зүй”-н стандартын 30 цагийн сургалтанд хамрагдаж, шалгалтыг өгч сертификатыг авсан.<br>05 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд чанарын менежментийн тогтолцоо-шаардлага стандартын магадлах аудитыг цахимаар хийгдэж, холбогдох журмуудад өөрчлөлтийг оруулж, ISO стандартын хүрээнд хийсэн ажлаа хамгаалж, 77,1 хувьтайгаар үнэлэгдсэн байна.<br>Мөн хэлтсийн мэргэжилтэн С.Бүжинлхам, Н.Жаргалмаа нар байгууллагын “Дотоод аудит”-ын багт томилогдож дотоод аудитыг эхний хагас жилийн байдлаар хийж гүйцэтгэн, судалгааг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгтгүүлж, батламжилж буй байгууллагад хүргүүлсэн. Мэргэжилтнүүдийн Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж ажиллах заалтыг тусгаж, ажил хэргийн хавтас болон компьютерийн файлын эмх цэгцэд хяналт тавин ажиллаж байна. | |
| | **ДҮН** | | | | | | | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*
ЗДТГ-ЫН ДАРГА

**Төсвийн шууд захирагч** /Т.ХИШИГБААТАР/
*(огноо)* 2025.06.25

*Тайлагнасан:*
СТСХ-ийн дарга

**Нэгжийн дарга** /С.БАЙГАЛМАА/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* 2025.06.06 *(огноо)*

0320110002
9007342 СТ7121
0324020016
ТУЗ4247 9007342

## САНХҮҮ,ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С. БАЙГАЛМААГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Санхүү,төрийн сангийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 94.3 % | 66.01 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Сургалт ( Хууль тогтоомж ) | 100 | 15 |
| 2. | | | |
| 3. | | | |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15. |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | *70 хүртэлх оноо*<br>66,01 |
| 1 | 2 | 3 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>15 |

| | | |
|---|---|---|
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *..... оноо* |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

Засаг даргын Тамгын газрын дарга ............................ / Т.Хишигбаатар /

2025.06.28

0320110002

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

Санхүү,төрийн сангийн хэлтсийн дарга . ............................ / С.Байгалмаа /

2025.06.06

0324020016
ТУ3424Т 9007342